



**МОНГОЛ УЛСЫН
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ**

Засгийн газрын XI байр, Самбуугийн гудамж 11,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15141
Утас: 26 42 16, Факс: (976-51) 26 44 60,
Цахим шуудан: info@csc.gov.mn,
Цахим хуудас: www.csc.gov.mn

2025.04.03 № 06/744

танай _____-ны № _____-т

Тогтоол хүргүүлэх тухай

Төрийн албаны зөвлөлийн даргын 2025 оны 35 дугаар тушаалаар байгуулагдсан шалгалтын комисс тус Ажлын албаны Үнэт цаасны газрын даргын удирдах албан тушаалын сул орон тоог нөхөх сонгон шалгаруулалтыг холбогдох журмын дагуу зохион байгууллаа.


Тухайн албан тушаалд өрсөлдөхөөр хүсэлт ирүүлсэн Баттулгын Дөлгөөн нь Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.1-т заасан тусгай шаардлага, мөн хуулийн 26 дугаар зүйлийн 26.3-т заасан шалгуурыг ханган, шатлан дэвшиж буй төрийн жинхэнэ албан хаагч бөгөөд шалгалтад нийт 100.0 оноо авахаас 68.3 оноо авч тэнцсэн болно.

Сонгон шалгаруулалт зохион байгуулсан комиссын тайланг Төрийн албаны зөвлөлийн 2025 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн ээлжит хуралдаанаар хэлэлцээд Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын албаны Үнэт цаасны газрын даргын албан тушаалд Б.Дөлгөөнийг албан тушаалын тодорхойлолтын шаардлага хангасан байдал болон шалгалтын үнэлгээг харгалзан нэр дэвшүүлсэн Төрийн албаны зөвлөлийн тогтоолыг хүргүүлж байна.

“Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн 23 дугаар зүйлийн 23.5, Төрийн албаны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.5 дахь заалтыг тус тус хангаж байгаа баримтыг холбогдох байгууллагаар хянуулан зөвшөөрөл авч, нэр дэвшигчийг томилсон шийдвэрийн хамт ирүүлнэ үү.

Хавсралт .x хуудастай.

АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА



В.ЖАВЗАН

1525071606



МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 04 сарын 02 өдөр

Дугаар 149

Улаанбаатар хот

Нэр дэвшүүлж, санал болгох тухай

Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.1 дэх заалт, 65 дугаар зүйлийн 65.6 дахь хэсэг, Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам"-ын 12.1 дэх заалт, Төрийн албаны зөвлөлийн даргын 2025 оны 35 дугаар тушаалаар байгуулагдсан шалгалтын комиссын санал, үнэлгээг тус тус үндэслэн Монгол Улсын Төрийн албаны зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын албаны Үнэт цаасны газрын даргын албан тушаалын сонгон шалгаруулалтад оролцсон Баттулгын Дөлгөөн нь 100 оноо авахаас 68.3 оноо авч тэнцсэн тул тухайн албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлсүгэй.

2. Нэр дэвшигч Б.Дөлгөөнийг Үнэт цаасны газрын даргын албан тушаалд томилохыг Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын алба (Б.Итгэлсүрэн)-д санал болгосугай.

3. Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, тухайн албан тушаалын чиг үүрэгт хамаарах бусад хууль, тогтоомж, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, "Шинэ сэргэлтийн бодлого"-ыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж, манлайлал, ёс зүйтэй ажиллахыг нэр дэвшигч (Б.Дөлгөөн)-д зөвлөсүгэй.

ДАРГА



Л.ЦЭДЭВСҮРЭН

1525010392

